






Монгол хэл мөхөж байгаа юу!?

Эх хэлний талаарх мэдээлэлд олон нийт сонор соргог байгаа энэ үед “монгол хэл мөхөж байна” гэж хэлний бодлогын алба хашигчаас эхлээд хэн хүнгүй хэлэх шахаж байна. Ингэж хэлээд байгаагийн шалтгаан нь эргэн тойрон харагдах эрээн мяраан хаяг, сурталчилгаанаас эхлээд гар утас, компьютерт хэрэглэх харь үг, улмаар гадаад үг холин хэлэлцэх хүүхэд залуус, тэр ч байтугай сэтгүүлч, улс төрчдийн үг хэлнээс урган гарсан эмзэглэл юм. Ингээд бодохоор бид ч бас эх хэлээ анхаарч сүйрч мөхөх вий хэмээн болгоомжилж байдаг ард түмэн ажээ.

Хэлний мөхөл хэмээх үг нь сүүлийн үед гарч ирсэн томъёолол агаад дэлхий дээр жилд 18-20 жижиг хэл устаж үгүй болдог гэсэн судалгааны дүнд тулгуурлан НҮБ-ийн Боловсрол, соёл, шинжлэх ухааны төрөлжсөн байгууллага болох ЮНЕСКО-оос улс үндэстний эх хэлийг хамгаалах талаар дэлхий нийтээр “эх хэлний өдөр”-ийг 2000 оноос эхлэн тэмдэглэж, эх хэлний талаар олон чухал уриалгыг гаргасаар 14 жил болж байна. Устан мөхөх гэж буй хэлийг хамгаалах зорилгоор мөхөж буй хэлний зураглал буюу атласыг ч хийсэн байна. Үүнд мөхсөн хэл хийгээд хамгаалах шаардлагатай хэлний 5 түвшинг тогтоож өгсөн байна.

-  -Эмзэг хэл. Хүүхдүүд тухайн хэлээрээ ярих боловч зөвхөн гэртээ ярих зэрэг хязгаарлагдмал орчинд ярьдаг хэл.
-  -Мөхөж эхэлж буй хэл. Хүүхдүүд нь эх хэлээрээ хэлд орохгүй өөр хэлээр хэлд ордог хэл.
-  -Мөхөхөд ойрхон хэл. Тухайн хэлээр настангууд нь ярьж, дунд насныхан нь ойлгодог ч хүүхдүүдтэйгээ ярьдаггүй хэл.
-  -Мөхлийн ирмэгт байгаа хэл. Тухайн хэлээр хэлэлцэгчид нь настангууд байж, өөр хэлтэй холин ярьдаг болон ховорхон ярьдаг хэл.
-  -Мөхсөн хэл. 1950 оноос хойш тухайн хэлээр ярьдаг хүнгүй болсон хэл хэмээн ангилжээ.

Энэ шалгуурыг монгол хэлтэй харьцуулж үзвэл 1950 оноос хойш ярьдаг хүнгүй болсон мөхсөн хэл огт биш, мөн хааяа болон настангууд, дунд насныхан нь зөвхөн ярьдаг хэл бас биш хүүхэд залуус ер нь бүх насныхан хязгаарлагдмал хүрээнд бус нийтлэг хэрэглэдэг хэл учир хэлний “улаан ном”-д эх хэл минь ороогүй байна.

Харин тухайн улс үндэстэн өөрийн тусгаар байдлаа алдаж аль нэгний эрхшээлд орсон бол дээрх аюул нүүрлэхийг үгүйсгэхгүй юм. Энэ байдал бидний мэдэх монгол угсаатан Халимаг, Буриад, Өвөрлөгчдөд илүү мэдрэгдэж байна. Халимаг, буриад залуус өөр хоорондоо оросоор ярих нь элбэг, монголоор ярьдаг залуус цөөн, настайчууд ихэвчлэн монголоор ярьдаг юм билээ. Өвөрмонголд ч мөн адил хүүхдийг монгол сургуульд суулгах нь эрс багасч, хятад сургуульд анхлан суулгаж байгаа нь эх хэлээ мартахын шалтгаан болно. Тэгэхээр хэдийгээр тэд монгол угсаатан ч улс төрийн нөхцөл байдлаас шалтгаалан аажмаар устах зам руу орж явж байгаа нь харагдаж байна. Ийм учраас буриад хэлийг

хэлний “улаан ном”-д саяхан оруулсан юм. Энэ мэт байдлаас шалтгаалан хэл мөхснийг бид монгол болон хятадыг 200 гаруй эрхшээлдээ байлгасан Манж гүрний жишээнээс мэдэх билээ. Манж гүрэн устаж, манж хэл ялангуяа ярианы хэл мөхсөн түүхийг шуудай цагаан будаан дотор аяга шар будаа хийсэнтэй жишиж үздэг нь олонхийн дотор цөөнх үндэстэн хэрхэн устаж, хэлээ мартаж болдгийг бэлхэнээ харуулсан билээ.

Энэ бодит байдлыг дэлхийн олон хэлний мөхлийн шалтгааныг судалсан эрдэмтэн Дэвид Кристал үзэхдээ “тухайн хэлээр ярьдаг хүнгүй буюу үндэстэнгүй болвол хэл гарцаагүй мөхнө” хэмээн баталсан байдаг. Эндээс дүгнэлт хийж үзвэл тухайн хэлээр ярихгүй болвол хэл мөхдөгь ярих хүн олширвол хэл хөгжиж байна хэмээн үзэж болох нь. Монголчууд бид өсөөд 3 сая орчим болж байгаа нь монголоор ярих хүний тоо нэмэгдэж, эх хэл хөгжиж байгаагийн баталгаа биш гэж үү?

Эх хэл хөгжихийн зэрэгцээ даяаршлын эрин зууны нөлөөгөөр бусад хэлний нөлөө тусах үзэгдэл багагүй байна. Монгол хэлний түүхийг сөхөн үзвэл хөрш зэргэлдээ болоод улс төр эдийн засгийн харилцаатай холбоотой байсан араб, перс, энэтхэг төвд, хятад, орос хэлний үг тодорхой хэмжээгээр үгийн санд орсон байдаг. Үүний нэгэн адилаар голдуу англи хэлнээс 1990-ээд оноос хойш үеэс цөөнгүй үг монгол хэлнээ оржээ. Энэ хугацаанд чухам хэд орчим үг орсныг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл “Өдрийн сонин”, “Зууны мэдээ”, “Өнөөдөр” болон интернет хуудаснаас түүвэрлэн судлахад 1000 орчим байдаг. Гэтэл гудамж талбайгаар дүүрэн англиар бичсэн хаяг, сурталчилгааг харсан хэн ч гэсэн 1000-аас илүү хэмээн бодох нь зүйн хэрэг. Үүний дотор олон улсад танигдсан бүтээгдэхүүний нэр, оноосон нэр, товчилсон нэр гээд үгийн санд шууд нэвтрэхгүй үг цөөнгүй байгааг хэлэх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, “Манхэтэн” гэдэг зоогийн газрын нэр монгол хэлний үгийн санд шууд нэвтрэхгүй, оноосон нэрийнхээ үүргээр байна гэсэн үг.

Нэг зүйлийг нэмэн тэмдэглэхэд бидний эх хэлэнд нөлөөлөх улс төрийн хүчин зүйл болох хоморголон устгах, колончлогдох үйл явцад өртөөгүй атал монголчууд бид өөрсдөө эх хэлээ “эрэмдэглээд” эцэст нь мөхөл рүү түлхээд байгаа юм биш үү.

Бид монголоор ярихаас илүү чамирхаж яриандаа гадаад үг хавчуулан, эсвэл хүүхдэдээ зааж байна гэж гадаад хэлээр ярьж, нэг компани байгуулвал гадаад нэр өгч, хаяг сурталчилгаагаа болж өгвөл гадаад хэлээр хийчих гээд байгаа нь хэн нэгэн Жон, Ким, Иваны хийсэн хэрэг огтоос биш гэж бодож байна. Тэгэхээр хэлээ мөхөөх эсэх нь та биднээс хамаарч байгаа бус уу.

Их далай хог сагаа эрэг рүүгээ шидлэн цэвэрлэдэг шиг хэл өөрийн дотоод хууль зүй тогтолдоо нийцэхгүй байгаа зүйлийг авалгүй орхидог хуультай ч энэ хуулинд бүрэн найдалгүй өөрсдөө ухамсартайгаар зохицуулах хууль, түүний хэрэгжилтэнд анхаарах цаг болжээ.

Даяарших үйл явц, олон соёлын нөлөөллийн дор оршин байгаа бидний монгол хэл мөхөх аюултай юу гэвэл, аюултай, гэвч мөхлөөс холуур авч гарах, хөгжүүлэхийн тулд

монгол хүн бүр сэтгэлээ чилээж, хэлний бодлогод захирагдах нь чухал юм. Үүнтэй уялдуудан тэмдэглэхэд, ЮНЕСКО-оос энэ жилийн “эх хэлний өдөр”-ийг “Дэлхийн иргэншилд хүргэх эх хэл: Шинжлэх ухаан бүгдийн анхааралд” гэсэн уриатай гаргаж, түүндээ “ Эх хэл бол орчин цагийн математик, физик, технологи гэх мэт шинжлэх ухааны мэдлэгийг бүхэлд нь бүрэн төгс дамжуулж чадах үгийн арвин их баялаг юм” хэмээсэн нь техник технологийн үг хэллэг болгоныг англи үгээр аваад байх гэсэн санаа биш юм.

Хэлний мөхөл гэдгийг хүн болгон яриад, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр цацаад байх юм биш ээ. Хэл мөхөж байна гэдэг үгийн цаана бидний улс үндэстэн мөхөж байна гэсэн давхар утга явж байдгийг мартаж болохгүй.

Хэл зохиолын хүрээлэнгийн
Хэрэглээний хэл шинжлэлийн ЭШАА,
доктор (Ph.D) Г.Гэрэлмаа